



Байнгын хорооны хуралдааны тэмдэглэл
2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БОЛОН ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2026 оны 06 дугаар сарын 30-ны өдөр Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-5

1.Монгол Улсын олон улсын гэрээний биелэлтийн талаарх
Засгийн газрын тайлан

4-5

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Хууль зүйн байнгын
хороодын 06 дугаар сарын 30-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хамтарсан хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Н.Наранбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 52 гишүүнээс 30 гишүүн хүрэлцэн ирж, 57.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 19 цаг 08 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Х.Баттулга, Э.Батшугар, Э.Бат-Амгалан, Ж.Баярмаа, Г.Дамдинням, С.Одонтуяа, Л.Оюун-Эрдэнэ, Ж.Энхбаяр;
Тасалсан: Б.Батбаатар, Д.Бум-Очир, Э.Болормаа, Д.Ганбат, Б.Дэлгэрсайхан, Б.Жаргалан, Ө.Шижир, Р.Эрдэнэбүрэн.

Нэг.Монгол Улсын олон улсын гэрээний биелэлтийн талаарх Засгийн газрын тайлан

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны референт А.Наранцэцэг нар байлцав.

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар Монгол Улсын олон улсын гэрээний биелэлтийн талаарх Засгийн газрын тайланг хэлэлцэхэд Гадаад харилцааны сайдыг байлцуулах шаардлагатай тул хуралдааныг хойшлуулъя гэсэн горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	16
Татгалзсан:	14
Бүгд:	30

53.3 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул Монгол Улсын олон улсын гэрээний биелэлтийн талаарх Засгийн газрын тайланг хэлэлцэхийг хойшлуулав.

Хуралдаан 03 минут үргэлжилж, 52 гишүүнээс 35 гишүүн хүрэлцэн ирж, 67.3 хувийн ирцтэйгээр 19 цаг 11 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 06 дугаар сарын 30-ны өдөр,
Лхагва гараг Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим 19 цаг 08 минут

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БОЛОН ХУУЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Өнөөдөр Хууль зүйн байнгын хороо, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороодын хамтарсан хуралдаан хийхээр бэлдсэн байсан. Энд гол хэлэлцэх асуудал бол Олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн биелэлтийн асуудлыг хэлэлцэхээр төлөвлөсөн байсан. Энд тэгэхээр өнөөдрийн байдлаар урьд нь бол ГХЯ-ны хүсэлтийн дагуу 2 удаа энэ асуудлыг хойшлуулсан байсан. Өнөөдөр бол Хууль зүйн сайд байна, Гадаад харилцааны сайд ажилтай өнөөдөр энд ирж амжихааргүй байна. Тэгэхээр энэ асуудал бол хэлэлцэх их нарийн нарийн асуудлууд байгаа учраас энийг хойшлуулъя гэсэн горимын санал гаргаж байна аа. Тэгээд энэ горимын саналаар санал хурааа гэж бодож байна.

Өнөөдрийн тэгэхлээр хамтарсан хуралдааны ирц бол бүрдсэн байна. Ирцийг би танилцуулъя.

Ирц 57.7 хувиар ирц бүрдсэн байна. Алтангэрэлгишүүн, Баярбаатар гишүүн, Номинчимэг гишүүн, Сайнзориг гишүүн, Тулга гишүүн, Даваагийн Цогтбаатар гишүүн, Анар гишүүн, Жанганбыл гишүүн, Наранбаяр гишүүн, Хосбаяргийшүүн, Баасанжаргал гишүүн, Мөнхбаатар гишүүн, Пүрэвдаваа гишүүн, Сандаг-Очир гишүүн, Тэмүүжин гишүүн, Эрдэнэболд гишүүн, Бадамсүрэн гишүүн, Лүндэггишүүн, Очирбат гишүүн, Энхнасан гишүүн, Батлут гишүүн, Нарантуяа-Нара гишүүн, Пүрэвдорж гишүүн, Соронзонболд гишүүн, Дамдины Цогтбаатар гишүүн, Амгаланбаатар гишүүн, Батсүмбэрэл гишүүн, Мөнхбат гишүүн, Тэмүүлэн гишүүн, Энхтүвшин гишүүн гэсэн энэ ирцтэйгээр ирц бүрдсэн байна аа.

Ингээд ирц бүрдсэн тул хуралдаан нээснийг мэдэгдье.

Ингээд Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг сая танилцууллаа.

Тэгээд өнөөдөр хэлэлцэх асуудал бол энэ. Хамтарсан хуралдаанаар Олон улс улсын гэрээ хэлэлцээрүүдийн биелэлтийн тухай асуудлыг Засгийн газрын тайланг хэлэлцэх ёстой байсан. Ингээд 2 сайд ирж оролцох ёстой.

Хоёр Байнгын хороо хуралдаж байхад 2 сайд бол заавал байх ёстой. Хууль зүйн сайд бол өнөөдөр ирсэн байна. Гадаад харилцааны сайд өнөөдөр ирж амжаагүй ажилтай байгаа тул энэ хуралдааныг хойшлуулъя гэсэн горимын санал гаргаж байна аа.

Тэгээд хойшлуулъя гэсэн горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтдаа бэлдээрэй гишүүд.

Саяын горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

53.3 хувиар санал дэмжигдлээ.

Номинчимэг гишүүн, Эрдэнэболд гишүүд.

Номинчимэг гишүүн, Эрдэнэболд гишүүн, 2-ыг дэмжсэнд тооцож оруулаарай.
Ингээд хуралдаан тарлаа. Гишүүддээ баярлалаа.

19.11 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА